

## **Хүний нөөцийн удирдлагын ил тод байдал, хэрэгжүүлж буй ажил арга хэмжээ**

### **1. “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг боловсруулан, хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:**

- Улсын их хурал, Засгийн газраас баталсан цалингийн сүлжээг баримтлан төрийн албан хаагчдын цалин, нэмэгдлийг тухай бүрд нь шинэчлэн тогтоож олгоно.
- Албан хаагчдад сар бүр унаа, хоолны зардлыг олгоно.
- Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг дүгнэж, хууль тогтоомжид заасны дагуу урамшуулал, үр дүнгийн асуудлыг шийдвэрлэнэ.
- Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах асуудлыг төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- Ажлын байрны тохижилт, шинэчлэлтийг орчин үеийн оффисын стандартын жишигт нийцүүлэн тохижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, ая тухтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай материаллаг бааз, компьютер, техник хэрэгслээр хангах асуудлыг албан хаагчдаас санал авч судалгаа хийсний үндсэн дээр жил бүрийн төсөвт тусган шийдвэрлэнэ.
- Ар гэрт нь гачигдал гарах, үр хүүхэд, төрсөн ах дүү, хүүхэд нь хуримаа хийх, сургууль төгсөх, диплом, эрдмийн зэрэг хамгаалах зэрэг хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд байгууллагаас цалинтай чөлөө олгоно.
- Хөдөлмөрийн чадвараа алдсан гэр бүлийн гишүүнээ тэтгэх, албан хаагийн өрхийн орлого буурч нэг гишүүнд ногдох хэмжээ нь амьжиргааны баталгаажих доод түвшинд хүрэхгүй болсон, ар гэрт нь гачигдал тохиолдсон зэрэг нөхцөлд байгууллагаас нэг удаагийн тэтгэмж, туслалцаа олгоно.
- Ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулна.
- Хувиараа мэргэжил эзэмших, мэргэшлийн зэрэг ахиулах болон бусад сургалтад хамрагдаж байгаа албан хаагчдыг ажлаас нь түр хугацаагаар чөлөөлөн мэдлэг, мэргэшлээ дээшлүүлэх нөхцөл бололцоогоор хангана.
- Шинээр ажилд томилогдсон албан хаагчдад байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, дотоод журам болон төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм зэрэг шаардлагатай мэдээллийн талаар танилцуулна.
- Албан хаагчдыг жилд 1-ээс доошгүй удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээ хийлгэх, эмчлүүлэх шаардлагатай албан хаагчдыг тухай бүрд нь эмчилгээ сувилгаа хийлгэх, витаминжуулалтад хамруулах зэрэг эрүүл мэндийг нь хамгаалахад дэмжлэг үзүүлнэ.
- Албан хаагчдаа өвчлөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, спорт зааланд тоглуулах, зэрэг төрөл бүрийн спортын арга хэмжээнд хамруулж спорт, биеийн тамирын арга хэмжээг тогтмолжуулна.

- Баяр, ёслол, амралтын өдрийг хамт олноороо тэмдэглэн өнгөрүүлэх, аялал зугаалга зохион байгуулах, урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах зэрэг албан хаагчдыг үр бүтээлтэй амрах, алжаалаа тайлах нөхцөл бололцоогоор хангана.

зэрэг дээрх үйл ажиллагааны чиглэлээр тухай бүр хэрэгжүүлэн ажилласан.

2025 оны байдлаар хөтөлбөрийн хэрэгжилт 86.5%-тай хэрэгжсэн.

2025.12.11